# ХӨВСГӨЛ АЙМГИЙН УЦУОШТ-ИЙН ЦАГ УУРЫН ХАРУУЛЫН АЖИГЛАГЧИЙН АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ

## 1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

| | |
|---|---|
| **Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:** Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан | |
| **Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:** ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга, 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдөр | |
| **Дагаж мөрдөх огноо:** 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. | |
| **Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:** | |
| **Байгууллагын нэр:** хөвсгөл аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төв | **Нэгжийн нэр:** Цаг уур, орчны технологийн хэлтэс |
| **Албан тушаалын нэр:** Харуулын ажиглагч | **Албан тушаалын ангилал, зэрэглэл:** ТҮМ-4 |
| Ажлын цаг: 1 өдөрт 8 цаг | **Ажлын байрны албан ёсны байршил:** Хөвсгөл аймгийн ............. сум |
| **Хөдөлмөрийн нөхцөл:** Хөдөлмөрийн хэвийн нөхцөл | **Онцгой нөхцөл:**<br>1. Нийтээр амрах баярын өдрүүд болон амралтын өдрүүдэд ажиллана.<br>1. Гадаа ажиллана, 5 км хүртэл явж, зарим үед цаг агаарын хүндэрсэн нөхцөл, цаг агаарын аюултай үзэгдэл, байгалийн гамшигт үзэгдлийг ажиглаж, хэмжилт хийх болдог. |

## 2. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

| | | | |
|---|---|---|---|
| **Ажлын байрны зорилго:** | Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний харуулын шинжилгээ, мэдээлэл үйлчилгээний ажлын хөтөлбөрийг хангаан биелүүлэх, ус цаг уур, орчны мэдээллээр сумын Засаг даргын тамгын газар, аж ахуйн нэгж, иргэдийг хангах ажлыг зохион байгуулах. | | |
| **Зорилт** | **Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг** | **Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт** | **Хариуцлага, оролцооны хэлбэр**<br>Туслах - **Т**,<br>Хариуцан гүйцэтгэх - **Г**<br>Хянах – **Х**<br>Шийдвэрлэх – **Ш** |
| **1 дүгээр зорилтын хүрээнд:** Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний ажлын хөтөлбөрийг чанарын өндөр түвшинд хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах. | 1.1. Хөтөлбөрт ажлыг бүрэн хэрэгжүүлэх төсөв, хэмжлийн багаж төхөөрөмж, материалыг захиалан авч хангах.<br>1.2. Харуулын жилийн ажлын төлөвлөгөөг сумын Засаг дарга болон УЦУОШТ-ийн даргаар батлуулж ажиллах.<br>1.3. Ажиглалтын материалд хийсэн техник шалгалтын чанарт хяналт тавьж гарсан дутагдлыг тухай бүр нь засах арга хэмжээ авах. | 1. Харуулын жилийн ажлын төлөвлөгөөг батлуулснаар тасралтгүй нөхцөл хангагдана.<br>2. Хяналт шинжил-гээний ажлыг гүйцэт-гэхэд шаардлагатай хэмжлийн багаж, төхөөрөмж сэлбэг материалыг захиалан авсан байна.<br>3. Хөтөлбөрт заасан УЦУОХШ-ний ажиглалтыг цаг тухайд нь үнэн зөв хийж | |

| | | | |
|---|---|---|---|
| | 1.4. Сарын тайланг хугацаанд нь үнэн зөв чанартай хийж материалыг шуудангаар илгээх.<br>1.5. МУ-ын ЗГ-ын 2015 оны 286-р тогтоолын дагуу бэлчээрийн даац багтаамжийг тодорхойлох, өвөл зуны явуул судалгааг сумын засаг даргын тамгын газартай хамтран хийж тайлан мэдээг хугацаанд нь УЦУОШГ-т | хяналтын хугацаанд нь дамжуулсан байх | |
| **2 дугаар зорилтын хүрээнд:**<br><br>Ус цаг уур, орчны тухайн хугацааны болон байгаль цаг агаарын аюултай үзэгдлийн тухай мэдээллийг зааварт заасан хугацаанд дамжуулах. | 2.1. Цаг уурын ажиглалтыг технологийн дагуу ажиглан коодлон хяналтын хугацаанд нь дамжуулах.<br>2.2. ХАА-н цаг уурын ажиглалтыг мөн батлагдсан хөтөлбөрийн дагуу чанартай сайн хийж гүйцэтгэх<br>2.3. Байгаль цаг агаарын болзошгүй аюултай болон гамшигт үзэгдэл ажиглагдсан тухай бүрд нь Байгаль орчны сайдын 1995 оны 148 дугаар тушаалаар баталсан “Ус цаг агаарын аюултай үзэгдэл болох үед Ус цаг уурын шинжилгээний станц харуулын ажиллах журмыг мөрдөж ажиллах.<br>2.4. Аюул, агаар мэдээг ажиглаж хяналтын хугацаанд нь технологийн болон зааврын алдаагүй үнэн зөв дамжуулах. | 1. Мэдээллийг бүрэн, шуурхай дамжуулс-наар өдөр тутмын шуурхай үйлчилгээ үзүүлэх, учирч болох аюул, гамшгаас урьдчилан сэргийлэх боломж бүрдсэн байх.<br>2. Харуулын горимын мэдээ хөтөлбөрт заасны дагуу үнэн зөв ажиглаж хяналтын хугацаандаа дамжсан байх. | |
| **3 дугаар зорилтын хүрээнд:**<br>Ус цаг уур, орчны шинжилгээний ажлын хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах. | 3.1. Хүчтэй салхи, шуурга, хэт халуун, хүйтэн зэрэг цаг агаарын хүнд нөхцөл, шөнийн хугацаанд ажиглалтыг хөдөлмөрийн аюулгүй хэмжээнд хийх нөхцлийг хангах.<br>3.2.Аюулгүй ажиллагааны зааварчлага өгсөн дэвтэр хөтлөх | Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааврыг заасан хугацаанд нь танилцуулж заавар-чилгаа өгөх, тухайн гүйцэтгэхэд ажлыг шаардлагатай хам-гаалах болон аврах хэрэгсэл, хувцсаар хангаж ажилласнаар цаг агаарын аюултай болон онц аюултай үзэгдэл ажиглагдаж байгаа үед ямар нэгэн осол, гэмтэл гараагүй, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа хангагдсан байх. | |
| **4 дүгээр зорилтын хүрээнд:**<br>Харуулын цаг уур, ХААЦУ-ын шинжил-гээний тайлан материалд техник шалгалт хийж шалгалт | 4.1. Ус цаг уур, орчны шинжилгээний ажиглалтын материалд сар бүр техник шалгалт хийж шүүмж шалгалтанд шилжүүлэх<br>4.2. Шалгалтаар илэрсэн алдааг засаж дахин гаргахгүй | Ажиглалтын явцад гарсан алдааг бүрэн илрүүлж, шинжилгээний ажлыг чанартай явуулах нөхцөл бүрдсэн байх. | |

| | | | |
|---|---|---|---|
| цахим хэлбэрт шилжүүлэх. | байх талаар санаачлагатай ажиллах.<br>4.3. Сар бүр цаг уурын ажиглалтын мэдээг цахим хэлбэрт оруулан ISX мэдээ үүсгэх. | | |
| **5 дугаар зорилтын хүрээнд:**<br>Ус цаг уур, орчны мэдээллээр сумын Засаг даргын Тамгын газар, аж ахуйн нэгж, иргэдэд үйлчлэх | 5.1. Мэдээлэл үйлчил-гээний хэлтсээс гаргаж буй цаг агаарын урьдчилсан мэдээг тогтмол хүлээн авч сумын удирдлагууд болон ард иргэдэд мэдээлэх. /Мэдээллийн самбарт тавих/.<br>5.2. Цаг агаарын аюултай болон онц аюултай үзэгдлээс “СЭРЭМЖЛҮҮЛЭГ” болон “УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ МЭДЭЭ” зарласан тохиол-долд цаг алдалгүй “Багц мэдээ“ –ний программ ашиглан сумын удирд-лагууд болон малчин өрх, ард иргэдэд ЦА-ын СМ болон УСМ, анхааруулга мэдээг мессежээр дамжуулах.<br>5.3. Байгаль цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдэл болж өнгөрсний дараа тухайн нутгийн хэмжээнд Сумын Засаг даргын тамгын газартай хамтарч явуул судалгааны ажлыг хийж үзэгдлийн эрчимшил хамарсан нутаг, гарсан хохирлын хэмжээг тодорхойлж мэдээлэх. | Нийтийн хэрэгцээнд зориулсан цаг агаарын урьдчилсан болон урьдчилан сэргийлэх мэдээллийг бүрэн хүлээн авч шуурхай дамжуулснаар болзошгүй аюулт үзэгдлээс сэрэмжлүүлэх нөхцөл бүрдэнэ. | |
| **6 дугаар зорилтын хүрээнд:** Байгууллага болон аймаг орон нутгаас зохион байгуулж буй олон нийтийн ажилд оролцох | 1. Удирдах албан тушаалтны өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэнэ.<br>2. Байгууллага болон аймаг орон нутгийн удирдлага, олон нийтээс зохион байгуулж буй ажилд идэвхи санаачлагатай оролцоно. | Аймаг орон нутгаас зохион байгуулж буй нийтийг хамарсан ажилд УЦУОШТ-ийн гүйцэтгэх үүрэг бүрэн биелэсэн байна. | |

## 3. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

| **Боловсрол** | **Дээд боловсролын бакалавр түүнээс дээш магистр** |
|---|---|
| **Мэргэжил** | Цаг уурын техникч, инженер |
| **Мэргэшил** | ЦУОШГ-аас зохион байгуулсан цаг уурын ажиглагчын сургалгалтанд суусан байх. |
| **Туршлага** | Цаг уурын өртөө, харуулд ажиллаж байсан туршлагтай<br>Эсвэл давтан сургалтанд хамрагдсан байх |
| **Ур чадвар** | - Цаг агаарын мэдээний талаар хэрэглэгчдэд мэдээлэл өгөх чадвартай байх<br>- Компьютерийн хэрэглээний программуудыг ашиглаж чаддаг байх |

## 4. АЛБАН ТУШААЛЫН ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

| | |
|---|---|
| **Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:** УЦУОШТөвийн дарга<br>Цаг уур, орчны технологийн хэлтсийн дарга, Цаг уур, ХААЦУ хариуцсан ерөнхий технологич инженерүүд, Ахлах техникчид | |
| **Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо:**<br><br>байхгүй | Бусад харилцах субъект:<br>Байгууллагын дотор:<br><br>• Мэдээлэл үйлчилгээний хэлтсийн дарга<br>• Салбар хариуцсан ерөнхий технологич инженерүүд<br>• Ахлах техникчид<br>• Өртөө, харуулын техникчид<br>• Синоптик инженерүүд<br>• Ня-бо, нярав<br>• Архив бичиг хэргийн эрхлэгч<br>• Бусад албан хаагчид<br>*Шууд харилцах байгууллага*:<br>УЦУОШТөв<br>*Шууд бус харилцах байгууллага*:<br>Ус цаг уур, орчны шинжилгээний мэдээллийг хэрэглэгч төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэд |

## 5. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

| **Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:** | **Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:** |
|---|---|
| **Албан тушаал:**<br><br>Цаг уур, орчны технологийн хэлтсийн дарга:<br>ЦУОТХ-н дарга..........................<br><br>.................................................. Б.Өнөрбат | Байгууллагын нэр: ..............<br><br>Шийдвэрийн огноо: ..............<br><br>Дугаар: ............… |
| **Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:** | |
| Байгууллагын нэр:..............<br><br>Шийдвэрийн огноо: ..............<br><br>Дугаар: ..............<br><br>(тамга/тэмдэг)<br>……………… ………………………..<br>(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) | |
| 20... оны ... дугаар сарын ... -ны өдөр | |

6.

| **Албан тушаалын тодорхойлолттой танилцаж зөвшөөрсөн :** |
|---|
| **......................................харуулын ажиглагч:**<br>……………… ………………………..<br>(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) |
| 20... оны ... дугаар сарын ... -ны өдөр |